


Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын-ныдугаар сарын ...-ний өдрийн
1/40 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ЭРСДЭЛ БОЛОМЖИЙГ ТОДОРХОЙЛОХ ЖУРАМ

БХ-ЭБТЖ-02-2024

Хувилбар 02

Баянхонгор аймаг
2024 он

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын ²⁰²⁴
оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 14 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ЭРСДЛИЙГ ИЛРҮҮЛЖ ҮНЭЛЭХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ЖУРАМ

БХ-ЭИҮХАХАЖ-02-2024
Хувилбар 02

Баянхонгор аймаг
2024 он

Баримт бичгийн нэр, дугаар :	Эрсдлийг илрүүлж үнэлэх, хариу арга хэмжээ авах журам БХ-ЭИҮХАХАЖ-02-2024	
Хувилбар 02	Боловсруулсан огноо : 2024.05.01 Мөрдөх огноо : 2024.05.15	Хуудасны тоо: 13

Агуулга

Д/д	Гарчиг	Хуудсын дугаар
1	2	3
1	Зорилго	4
2	Хамрах хүрээ	4
3	Норматив иш таталт	4
4	Нэр томьёо, тодорхойлолт	4-5
5	Үүрэг хариуцлага	5-6
6	Эрсдэл тодорхойлох арга замууд	6-7
7	Эрсдлийн хариу арга хэмжээ авах	7
8	Хавсралт	7
	Хавсралт 1 БХ- ЭИҮХАХАЖ-02-2024 Албан хаагчийн эрсдэл бүртгэх хуудас	8-10
	Хавсралт 02 БХ- ЭИҮХАХАЖ -02-2024 Эрсдлийн бүртгэлийн нэгтгэл	11
	Хавсралт 03 БХ- ЭИҮХАХАЖ-02-2024 Эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12
	Хавсралт 04 БХ- ЭИҮХАХАЖ-02-2024 Эрсдлийг үнэлэх үйл явцын зураглал	13

Баримт бичгийн нэр, дугаар :	Эрсдлийг илрүүлж үнэлэх, хариу арга хэмжээ авах журам БХ-ЭИҮХАХАЖ-02-2024	
Хувилбар 02	Боловсруулсан огноо : 2024.05.01 Мөрдөх огноо : 2024.05.15	Хуудасны тоо: 13

Баримт бичгийн түүх

№	Өөрчлөлт хийсэн огноо	Өөрчлөлт хийгдсэн бүлэг, зүйл, заалт	Өөрчлөлт хийсэн шалтгаан	Өөрчлөлт хийсэн ажилтан	Хянан баталгаажуулсан удирдах албан хаагч
1	2	3	4	5	6
1	2017.05.18	Бүх зүйл	Шинээр боловсруулсан.	Чанарын баг	Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Дашцэрэн
2	2024.05.01	Бүх заалт	Давтан баталгаажуулалт авахаар шинэчлэн сайжруулсан.	Чанарын баг	Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхжаргал
3	2024.06.06	Нэр, 1, 5, 6, 7, дугаар зүйл Хавсралт	1 дүгээр шатны аудитын үл тохирлыг залруулав.	Чанарын баг	Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхжаргал
4					
5					

Баримт бичгийн нэр, дугаар :	Эрсдлийг илрүүлж үнэлэх, хариу арга хэмжээ авах журам БХ-ЭИҮХАХАЖ-02-2024	
Хувилбар 02	Боловсруулсан огноо : 2024.05.01	Хуудасны тоо: 13
	Мөрдөх огноо : 2024.05.15	

Нэг. Зорилго

1.1.Энэхүү журмын зорилго нь Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаа, MNS ISO 9001:2016 стандартын 6.1 шаардлагыг хангах, эрсдлийг илрүүлэх, үнэлэх, удирдах, үйл явцыг төлөвшүүлэх, байнга сайжруулах зохицуулалт хийхэд чиглэнэ.

Хоёр.Хамрах хүрээ

2.1.Энэхүү журам нь аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаа, үйлчилгээ хамаарна. Засаг даргын Тамгын газрын санхүүгийн болон Цэргийн штабын маш нууц, нууц үйл ажиллагаанд хамаарахгүй.

Гурав.Норматив иш таталт

3.1 Энэхүү журамд иш татсан дараах норматив баримт бичиг нь түүний шаардлагын үндэслэл болох заалтуудыг агуулна. Хугацаат иш таталтын хувьд зөвхөн тухайн хэвлэлийг ашиглана. Хугацаагүй иш таталтын хувьд иш татагдсан норматив баримт бичгийн хамгийн сүүлчийн хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

3.1.1.MNS ISO 9000:2017-Чанарын менежментийн тогтолцоо-үндсэн ойлголт ба тайлбар толь;

3.1.2.MNS ISO 9001:2016-Чанарын менежментийн тогтолцоо–шаардлага;

3.1.3.MNS ISO 31000:2017-Эрсдлийн менежментийн тогтолцоо-зарчим ба заавар;

3.1.4.MNS ISO 9000: 2001-Чанарын удирдлагын тогтолцоо-Суурь асуудал, тайлбар толь;

3.1.5.MNS ISO GUIDE 73:2017-Эрсдлийн тайлбар толь;

Дөрөв.Нэр томьёо, тодорхойлолт

4.1.Энэхүү журамд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

4.1.1."Эрсдэл" гэж зорилтыг тодорхой бус болгож байгаа үр нөлөө;

4.1.2."Эрсдлийн менежмент" гэж эрсдэлийг чиглүүлэх, хянах зохицуулалт бүхий байгууллагын үйл ажиллагаанууд;

4.1.3."Эрслийн менежментийн төлөвлөгөө" гэж эрсдэлийн менежментийн хандлага, менежментийн хэрэгсэл, нөөцийг тодорхойлдог эрсдлийн менежментийн цар хүрээнд хамаатай аргачлал;

4.1.4."Гадаад нөхцөл байдал" гэж зорилтдоо хүрэхэд шаардагдах байгууллагын гадаад нөхцөл байдал;

Баримт бичгийн нэр, дугаар :	Эрсдлийг илрүүлж үнэлэх, хариу арга хэмжээ авах журам БХ-ЭИҮХАХАЖ-02-2024	
Хувилбар 02	Боловсруулсан огноо : 2024.05.01	Хуудасны тоо: 13
	Мөрдөх огноо : 2024.05.15	

4.1.5.“Оролцогч тал” гэж аливаа шийдвэр болон үйл ажиллагаанд нөлөөлөх, нөлөөнд өртөх эсвэл өртөж болзошгүй хүн буюу байгууллага ;

4.1.6.“Эрсдлийн үнэлгээ” гэж эрсдлийг тодорхойлох, эрсдэлийн шинжилгээ, болон эрсдэлд үнэлэлт өгөхтэй холбоотой бүх үйл явц;

4.1.7.“Эрсдлийг тодорхойлох” гэж эрсдлийг хайж олох, таних ба тайлбарлах үйл явц;

4.1.8.“Эрсдлийн эх сурвалж” гэж дангаар эсвэл хосолсон байдлаар эрсдлийг бий болгох дотоод хүчин зүйл бүхий бүрэлдэхүүн;

4.1.9.“Мэдээлэх ба зөвлөлдөх” гэж эрсдлийг удирдах талаар мэдээлэл олж авах, оролцогч талуудыг оролцуулж тэдний саналыг авах зорилгоор байнга хэрэгждэг үйл явц;

4.1.10.“Эрсдлийн түвшин” гэж эрсдэлийн үр дагаврууд түүний тохиолдох магадлалтай хосолсон байдлаар илэрхийлэгдэх нэг буюу хосолсон эрсдлийн хэмжээ;

4.1.11.“Үлдэгдэл эрсдэл” гэж эрсдлийн арга хэмжээ авсны дараа үлдэж байгаа эрсдэл;

4.1.12.“Залруулах” гэж эрсдлийн аюулыг бууруулах арга хэмжээ авах;

4.1.13.“Хамгаалах” гэж эрсдэлгүй үйл ажиллагаа, үйлчилгээг хадгалж үлдэх;

4.1.14.“Бууруулах” гэж эрсдлийн түвшинг багасгах арга хэмжээ авах;

4.1.15.“Арилгах” гэж эрсдлийг байхгүй болгох, устгах;

Тав.Үүрэг хариуцлага

5.1.Засаг даргын Тамгын газрын даргын үүрэг:

5.1.1.Энэхүү журмыг үр дүнтэй хэрэгжүүлэх хариуцлагыг хүлээнэ.

5.1.2.Байгууллагын хэмжээнд шаардлагатай хариу арга хэмжээний шийдвэр гаргана.

5.1.3.Эрсдлийн хариу арга хэмжээнд шаардагдах нөөцийн бэлэн байдлыг хангана.

5.2.Албан хаагчдын үүрэг хариуцлага

5.2.1.Энэхүү журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

Баримт бичгийн нэр, дугаар :	Эрсдлийг илрүүлж үнэлэх, хариу арга хэмжээ авах журам БХ-ЗИҮХАХАЖ-02-2024	
Хувилбар 02	Боловсруулсан огноо : 2024.05.01	Хуудасны тоо: 13
	Мөрдөх огноо : 2024.05.15	

5.2.2.Өөрийн ажлын байр, ажил, үйлчилгээнд хавсралт 01 дүгээр маягтын дагуу эрсдлийг бүртгэж, тухай бүр шууд удирдлагадаа танилцуулж, урьдчилан сэргийлж боломжит арга хэмжээ авна.

5.2.3.Заасан хугацаанд эрсдлийг бууруулах, арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй тохиолдолд хариуцсан албан тушаалтан, хэлтэс, албаны даргад Удирдлагын дүн шинжилгээний хурлын шийдвэрээр холбогдох хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.3.Чанарын багийн үүрэг, хариуцлага:

5.3.1.Албан хаагчдаас ирүүлсэн эрсдлийн үнэлгээг нэгтгэн, эрсдлийн шалтгааныг тодорхойлж, бүртгэн, 6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны дотор Удирдлагын дүн шинжилгээний хуралд танилцуулж, шийдвэр гаргуулна.

5.3.2.Удирдлагын дүн шинжилгээний шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, бүртгэл хөтлөн, сан үүсгэн, үр дүнг тооцно.

5.3.3.Эрсдэлүүдийг эрэмбэлэн дүгнэж, байгууллагын хүлээн зөвшөөрөх түвшнээс давсан эрсдлүүдэд шаардлагатай бол нэмэлт шинжилгээ хийнэ.

5.3.4.Эрсдлийн үнэлгээний хариуг удирдлага болон нийт албан хаагчдад танилцуулж, албан хаагчдыг мэдээллээр хангана.

5.3.5.Энэхүү журмын хэрэгжилтэд Чанарын баг, энэхүү журмыг хариуцсан багийн гишүүн хяналт тавина.

5.3.6.Журмын хэрэгжилтийг хангаагүй тохиолдолд холбогдох хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журмын дагуу хариуцлага хүлээнэ.

Зургаа.Эрсдэл тодорхойлох арга замууд

6.1.Байгууллагын бүхий л шатанд нэгж бүр өөрийн ажлын байр, үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдлийг тодорхойлж, үнэлгээ хийнэ.

6.2.Эрсдлийг дараах аргуудаас сонгон тодорхойлж болох ба энэ аргуудаар хязгаарлагдахгүй болно.

6.2.1.Ярилцлагын арга;

6.2.2.Дотоод, гадаад туршлага;

6.2.3.Хувь хүн, багийн туршлага;

6.2.4.Зохиомлоор нөхцөл үүсгэж, дүн шинжилгээ хийх;

6.2.5.Хяналт шалгалт, аудит;

6.2.6.Ажиглалт, бусад бүртгэл;

Баримт бичгийн нэр, дугаар :	Эрсдлийг илрүүлж үнэлэх, хариу арга хэмжээ авах журам БХ-ЭИҮХАХАЖ-02-2024	
Хувилбар 02	Боловсруулсан огноо : 2024.05.01	Хуудасны тоо: 13
	Мөрдөх огноо : 2024.05.15	

6.2.7.Шүүмж, бусад дүгнэлт;

6.2.8.Үйл явцын зураглал;

6.2.9.Шийдвэр гаргах дараалал /Жишээ нь: Төхиолдол тус бүрд дүн шинжилгээ хийх/;

6.2.10. Нэргүй судалгаа, асуулга авах;

6.2.11.Түүхэн буюу алдаж байсан зүйл дээр дүн шинжилгээ хийх /Жишээ нь: алдаа гаргаж байсан хэлбэрүүд, үр дүнгийн дүн шинжилгээ гэх мэт/;

Долоо.Эрсдлийн хариу арга хэмжээ авах

7.1.Эрсдэл хариуцагч нь Удирдлагын дүн шинжилгээний шийдвэрийн дагуу зөвшилцсөний үндсэн дээр эрсдлийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлнэ.

7.2.Эрсдлийн түвшнээс хамааран, эрсдлийг боломж болгох зохих арга хэмжээг авна. Үүнд

- Залруулах;
- Хамгаалах;
- Бууруулах;
- Арилгах;

7.3.Эрсдэл хариуцагч эрсдлийг засаж залруулсан арга хэмжээ авсан тухай тайланг тухай бүр чанарын баг болон удирдлагад танилцуулна.

Найм.Хавсралт

8.1.Хавсралт 1 БХ- ЭИҮХАХАЖ-02-2024 Албан хаагчийн эрсдэл бүртгэх хуудас;

8.2.Хавсралт 02 БХ- ЭИҮХАХАЖ -02-2024 Эрсдлийн бүртгэлийн нэгтгэл;

8.3.Хавсралт 03 БХ- ЭИҮХАХАЖ-02-2024 Эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө;

8.4.Хавсралт 04 БХ- ЭИҮХАХАЖ-02-2024 Эрсдлийг үнэлэх үйл явцын зураглал;

___оОо___

Баримт бичгийн нэр, дугаар :	Эрсдлийг илрүүлж үнэлэх, хариу арга хэмжээ авах журам БХ-ЭИҮХАХАЖ-02-2024	
Хувилбар 02	Боловсруулсан огноо : 2024.05.01	Хуудасны тоо: 13
	Мөрдөх огноо : 2024.05.15	

Хавсралт 1
БХ-ЭИҮХАХАЖ-02-2024

АЛБАН ХААГЧИЙН ЭРСДЭЛ БҮРТГЭХ ХУУДАС

20... оны ... сарын

Номгон

Нэгж хэлтэс:

Албан тушаал:

Овог нэр:

№	Эрсдлийн ангилал	Эрсдлийн нэр	Эрсдлийн шалтгаан	Эрсдлийн түвшин	Эрсдэл хариуцагч	P	N	H
1	2	3	4	5	6			
1								
2								
3								
4								
5								

R=P*N*H

R - эрсдэл

P - өмнө нь тохиолдож байсан эсэх

N – тухайн тохиолдолд гэмтэл бэртэл байсан эсэх

H – цаашид энэ зүйл гарах эсэх талаар гишүүдийн таамаглал

ЭРСДЭЛ БҮРТГЭСЭН:/...../
ТАНИЛЦСАН:/...../

Баримт бичгийн нэр, дугаар :	Эрсдлийг илрүүлж үнэлэх, хариу арга хэмжээ авах журам БХ-ЗИҮХАХАЖ-02-2024	
Хувилбар 02	Боловсруулсан огноо : 2024.05.01 Мөрдөх огноо : 2024.05.15	Хуудасны тоо: 13

Эрсдлийн ангилал ба түвшин хэсгийг бөглөхдөө дараах хүснэгтийг ашиглана.

Ангилал, түвшин	Маш их	Их	Дунд	Бага
1	2	3	4	5
Үйл ажиллагаа				
Санхүү				
Дэд бүтэц				
Хүний нөөц				
Харилцаа холбоо				
Хууль, эрх зүйн нийцэмж				
Байгаль орчин				
Байгууллагын нэр хүнд				
...				

Эрсдлийн түвшинг тодорхойлох тайлбар

Эрсдлийн түвшин	Эрсдлийг хянах арга хэмжээ
Үлэмж их Аюул Е	- Эрсдлийг маш яаралтай доод түвшин хүртэл бууруулах - Инженерчлэлийн аргаар үлдэгдэл эрсдлийг боломжит түвшин хүртэл бууруулах /захиргааны хяналтын арга нь тохиромжгүй/ - Хариуцагч нь эрсдлийн үнэлгээг дуусгалгүй хяналтаа үргэлжлүүлэх ёстой
Өндөр 5 Н	- Эрсдлийг яаралтай доод түвшин хүртэл бууруулах - Үлдэгдэл эрсдлийг hard and soft хяналтын аргыг хослуулан боломжит түвшин хүртэл бууруулах - Хариуцагч нь эрсдлийн үнэлгээг дуусгалгүй хяналтаа үргэлжлүүлэх ёстой.
Дунд зэргийн 3 М	- Эрсдлийг бууруулахын тулд тохирсон мониторингийг үргэлжлүүлэх эсвэл засаж сайжруулах арга хэмжээ авах - Эрсдлийн хяналтын гурвалжинг /аль ч хяналт болно/ ашиглан үлдэгдэл эрсдлийг боломжтой түвшин хүртэл багасгасан байх
Бага 1 Л	- Шаардлагатай хэсэгт засаж салруулах арга хэмжээ авах - Эрсдэл нь хүлээн зөвшөөрч болохуйц байх - Цаашид үлдэгдэл эрсдэлд нь хяналт шаардлагагүй

Баримт бичгийн нэр, дугаар :	Эрсдлийг илрүүлж үнэлэх, хариу арга хэмжээ авах журам БХ-ЗИҮХАХАЖ-02-2024	
Хувилбар 02	Боловсруулсан огноо : 2024.05.01 Мөрдөх огноо : 2024.05.15	Хуудасны тоо: 13

Магадлал	Эрсдэлд харгалзах оноо				
	1 Бага	2 Бага зэрэг	3 Дунд зэрэг	4 Их хэмжээний	5 Сүйрлийн түвшний
A –нийтлэг тохиолдох	H 11	H 16	E 20	E 23	E 25
B –боломжтой	M 7	H 12	H 17	E 21	E 24
C –магадлалтай	L 4	M 8	H 13	E 18	E 22
D –бараг тохиолдох боломжгүй	L 2	L 5	M 9	H 14	E 19
E –маш ховор тохиолдох	L 1	L 3	M 6	H 10	H 15

Эрсдлийн түвшинг дараах “Матриц”-ын аргыг ашиглан шинжилнэ

Баримт бичгийн нэр, дугаар :	Эрсдлийг илрүүлж үнэлэх, хариу арга хэмжээ авах журам БХ-ЭИҮХАХАЖ-02-2024	
Хувилбар 02	Боловсруулсан огноо : 2024.05.01	Хуудасны тоо: 13
	Мөрдөх огноо : 2024.05.15	

Хавсралт 2
БХ- ЭИҮХАХАЖ-02-2024

ЭРСДЛИЙН БҮРТГЭЛИЙН НЭГТГЭЛ

20... оны ... сарын

Номгон

	Эрсдлийн ангилал	Эрсдэл илрүүлсэн огноо	Эрсдлийн нэр	Эрсдлийн шалтгаан	Эрсдлийн түвшин	Болзошгүй үр дагавар	Эрсдэл хариуцагч	Хариу арга хэмжээ
1	2	3	4	5	6	7	8	9
1								
2								
3								
4								
5								

ТАНИЛЦСАН:/...../

ХЯНАСАН:/...../

БҮРТГЭЛ ХӨТӨЛСӨН
ЧАНАРЫН БАГИЙН ГИШҮҮН/...../

Баримт бичгийн нэр, дугаар :	Эрсдлийг илрүүлж үнэлэх, хариу арга хэмжээ авах журам БХ-ЭИҮХАХАЖ-02-2024	
Хувилбар 02	Боловсруулсан огноо : 2024.05.01	Хуудасны тоо: 13
	Мөрдөх огноо : 2024.05.15	

Хавсралт 3
БХ- ЭИҮХАХАЖ-02-2024

БАТЛАВ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Д.ЭНХЖАРГАЛ

... оны... сарын ...

ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨ

20... оны ... сарын

Номгон

№	Хэн ?	Юуг?	Хэзээ?	Хэрхэн хийх?
1	2	3	4	5

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:/...../
ХЯНАСАН:/...../

Баримт бичгийн нэр, дугаар :	Эрсдлийг илрүүлж үнэлэх, хариу арга хэмжээ авах журам БХ-ЭИҮХАХАЖ-02-2024	
Хувилбар 02	Боловсруулсан огноо : 2024.05.01	Хуудасны тоо: 13
	Мөрдөх огноо : 2024.05.15	

Хавсралт 4
БХ-ЭИҮХАХАЖ-02-2024

ЭРСДЛИЙГ ҮНЭЛЭХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГЛАЛ

